



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БАНК ХХК-ИЙН 2021 ОНЫ НЭГТГЭСЭН  
САНХҮҮГИЙН ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/50/НА-СТА-ТӨА

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх аудитор  
Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Д.Энхдалай  
Утас: 261885 Цахим хаяг: [enkhdalaid@audit.gov.mn](mailto:enkhdalaid@audit.gov.mn)  
Ахлах аудитор: П.Чанцалдулам  
Утас: 261740 Цахим хаяг: [chantsaldulamp@audit.gov.mn](mailto:chantsaldulamp@audit.gov.mn)  
Гэрээгээр гүйцэтгэсэн: Грант Торнтон аудит ХХК-ийн  
Партнер: Н.Эрдэнэцог  
Утас: 70770744 Цахим хаяг: [erdenetsog.n@mn.gt.com](mailto:erdenetsog.n@mn.gt.com)

Улаанбаатар хот  
2022 он

**АГУУЛГА**

1.Аудитын санал дүгнэлт .....	3
2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан.....	6
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан.....	6
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан .....	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан .....	9
3. Аудитын тайлан.....	10
3.1 Ерөнхий зүйл.....	10
3.2 Дотоод хяналт .....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	10
3.4 Материаллаг байдал .....	11
4. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
4.1 Байгууллагын үйл ажиллагаа.....	11
4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин .....	11
4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого .....	13
4.4 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт .....	13
4.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл.....	15
5. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
5.1 Шилэн дансны мэдээлэл .....	16
5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	18
7. Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
8. Аудитын илрүүлэлт .....	19
8.1 Төлбөрийн акт .....	19
8.2 Албан шаардлага.....	19
8.3 Зөвлөмж .....	23
9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	25
10. Хавсралт: Төлбөрийн акт, албан шаардлага .....	35

**Товчилсон үгийн жагсаалт**

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БҮЦ	Бондын үнэт цаас
ЗДТГ	Засаг Даргын Тамгын Газар
МИК	Монголын ипотекийн корпораци
НББОУС	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТОСК	Төрийн орон сууцны корпораци
ТУЗ	Төлөөлөн удирдах зөвлөл
ҮЦК	Үнэт цаасны компани
ӨҮЦ	Өрийн үнэт цаас
ӨБХ	Өмчлөх бусад хөрөнгө



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН  
БАНК ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ  
ЗАХИРАЛ Н.МАНДУУЛ ТАНАА

2022.03.15 № 07/631  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Хараат бус аудиторын тайлан

### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан 2017 оны “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 361 дүгээр тушаалын 01 дүгээр хавсралтын дагуу бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь нийт 66 хуулийн этгээдэд олгосон 3.2 их наяд төгрөгийн үндсэн зээл болон хүүгийн үлдэгдэлтэй, үүнээс хэвийн 27, анхаарал хандуулах 4, чанаргүй 35 зээлдэгч байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 3,206,508.3 сая төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй ба үүнээс 1,793,913.9 сая төгрөг буюу 56.2 хувь нь чанаргүй зээлийн ангилалд орж, зээлийн чанар илэрхий муудсан нөхцөл байдал үүссээр байтал зээлийн эрсдэлийн санг 583,216.6 сая төгрөгөөр буюу нийт зээлийн үлдэгдлийн 18.3 хувьтай тэнцэх хэмжээний эрсдэлийн санг байгуулсан нь бодит байдалтай нийцэхгүй ба журмын дагуу төрийн аудитын байгууллагын тооцоолсноор 792,680.0 сая төгрөгөөр нэмж байгуулах шаардлагатай байна.

Учир нь Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгө, эрсдэлээр жигнэсэн активын харьцааг хангахгүй болох, мөн олон улсын үнэлгээ буурснаар гадны банк санхүүгийн байгууллагуудаас санхүүжүүлсэн бондын эх үүсвэрүүд буцаан татагдах, Монгол Улсын зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул зээлийн эрсдэлийн санг бодитой байгуулаагүй байна.

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 792,680.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, тогтоосон материаллаг байдлын түвшнээс 772,581.0 сая төгрөгөөр давсан нь дангаараа буюу эсвэл нийтээрээ Нэгтгэсэн санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, санхүүгийн тайлангийн оршин байх, эрх ба үүрэг, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайлангийн аудитын гэрээ нь оройтож байгуулагдсанаас завсар үеийн аудитыг гүйцэтгээгүй, мөн төрийн бусад байгууллагуудын хяналт шалгалтууд давхцаж, зээлийн хувийн хэргүүдийг тэдэнд шилжүүлснээс шалтгаалан чанаргүй зээлдэгч нарын зээлийн хувийн хэрэгтэй нэг бүрчлэн танилцаж, шалгаж чадаагүй болно.

### **Асуудлыг онцолсон зүйл**

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ Сангийн сайдын баталсан 2017 оны “Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар” 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу бэлтгэж, толилуулсан.

Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх энэхүү заавар нь СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмууд дээр үндэслэсэн бөгөөд аж ахуйн нэгж байгууллагууд дотооддоо СТОУС болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн дагуу нягтлан бодох бүртгэлийн бодлогыг мөрдөж ажиллахыг шаарддаг боловч СТОУС-ын толилуулга болон тодруулгын шаардлагуудыг дагаж мөрддөггүй.

Мөн аудитлагдсан санхүүгийн тайлан нь Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх зааварт шаардсан бүрэн хэмжээний тодруулгыг хавсаргаагүй болно.

Тус банкны үйл ажиллагаа хүндэрсэнтэй холбогдуулан Монгол банк, Авлигатай тэмцэх газар, УИХ-аас томилогдсон ажлын хэсэг, Хөндлөнгийн аудитын компани зэрэг хяналт шалгалтын байгууллагууд хяналт, шалгалтын ажиллагаа нь энэхүү санхүүгийн тайлангийн аудиттай давхацсан ба эдгээр шалгалтын үр дүнд тус банкыг хүндрэлд хүргэсэн нөхцөл шалтгааныг тодорхойлж, холбогдох зээлдэгч, албан тушаалтан нартай хэрхэн хариуцлага тооцох, цаашид банкны үйл ажиллагааг хэрхэн хэвийн горимд оруулан, үр дүнтэй үргэлжлүүлэн явуулах талаар Улсын их хурал, Засгийн газраас зохих шийдвэр гарахаар хүлээгдэж байна.

## **Аудитын гол асуудлууд**

Бидний мэргэжлийн шийдлийн дагуу аудитын гол асуудалд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй зүйлсийг тодруулсан ба тэдгээрийг аудитын хүрээнд нэгтгэсэн байдлаар авч үзсэн болно.

Монгол банкны Ерөнхийлөгчийн баталсан Монгол Улсын Хөгжлийн банкны Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмын дагуу банк нь бүлгийн болон тусгайлсан аргаар эрсдэлийн сан байгуулдаг.

2021 оны 12 сарын 31-ний байдлаар төлбөрийн зөрчилгүй зээлийн хувьд бүлгийн аргаар, харин төлбөрийн зөрчилтэй зээлийн хувьд зээлийн барьцаа хөрөнгийн зах зээлийн үнэлгээнд үндэслэсэн ба барьцаа хөрөнгийг худалдан борлуулах хугацааг 1.5 жилээр тооцож, тухайн зээлийн үр ашигт хүүгээр дискаунтчилан өнөөгийн үнэ цэнийг тооцсон дүнг нийт зээлийн үлдэгдэлд харьцуулах аргачлалаар тусгайлсан аргаар зээлийн эрсдэлийн сан байгуулсан.

Энэхүү тооцоололд банкны удирдлагын тооцоолол, үнэлэмж, мэргэжлийн шийдэл ихээхэн оролцоотой тул аудитын гол асуудалд оруулав.

### **Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдүүдийн Нэгтгэсэн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага**

Удирдлага нэгтгэсэн санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон Монгол Улсад мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн үндсэн зарчмуудад бүрэн нийцсэн хүлээн зөвшөөрөлт, хэмжилтийн дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Нэгтгэсэн санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс нэгтгэсэн санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг нэгтгэсэн санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР **Ц.НАРАНЧИМЭГ**



## 2. Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн тайлан

## 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ХӨРӨНГӨ</b>		
<b>1.1</b>	<b>Эргэлтийн хөрөнгө</b>		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	360,484,279,771.86	333,986,473,036.47
1.1.2	Дансны авлага	3,691,724,985.49	792,926,274.62
1.1.3	Татвар, НД-н шимтгэлийн авлага	13,054,119,759.48	7,583,425,454.52
1.1.4	Бусад авлага	46,824,801.14	4,649,939,233.67
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	1,173,519,909,460.24	486,284,614,885.29
1.1.6	Бараа материал	7,890,555.50	11,996,911.84
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	8,604,300,692.54	1,757,989,360.31
1.1.10	Санхүүгийн түрээсийн авлага	85,259,492,881.15	74,062,793,014.72
	<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>	<b>1,644,668,542,907.40</b>	<b>909,130,158,171.44</b>
<b>1.2</b>	<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		
1.2.1	Үндсэн хөрөнгө	26,354,730,392.06	25,005,852,861.84
1.2.2	Биет бус хөрөнгө	535,142,994.57	381,199,757.04
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,326,097,484,647.22	2,833,602,666,691.25
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	14,844,238,249.63	23,707,845,632.36
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	17,776,829,583.68	89,649,660,188.50
1.2.9	Бусад эргэлтийн бус хөрөнгө	203,422,850,898.75	138,380,608,589.61
	<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>	<b>2,589,031,276,765.91</b>	<b>3,110,727,833,720.60</b>
	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>4,233,699,819,673.31</b>	<b>4,019,857,991,892.04</b>
<b>2</b>	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>		
<b>2.1.</b>	<b>Богино хугацаат өр төлбөр</b>		
2.1.1.1	Дансны өглөг	35,197,548,852.33	14,904,968,334.24
2.1.1.2	Цалингийн өглөг	17,505,094.55	1,761,606.54
2.1.1.3	Татварын өглөг	1,668,216,835.02	3,344,490,748.79
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,652,000.00	1,656,208.91
2.1.1.5	Богино хугацаат зээл	69,216,444,000.00	40,287,375,000.00
2.1.1.6	Хүүгийн өглөг	31,207,058,088.63	30,174,954,679.47
2.1.1.7	Дерватив арилжааны өглөг	12,234,986,837.77	-
	<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>149,543,411,708.30</b>	<b>88,715,206,577.95</b>
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	3,036,417,875,022.07	2,929,075,275,754.58
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	82,341,084.38	-
	<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>3,036,500,216,106.45</b>	<b>2,929,075,275,754.58</b>
	<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>3,286,043,627,814.75</b>	<b>3,017,790,482,332.53</b>
<b>2.2</b>	<b>Эзэмшигчдийн өмч</b>		
2.2.1	Өмч: а) төрийн	1,216,300,340,598.47	1,216,300,340,598.47
2.2.2	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	22,980,411,926.09	19,731,810,745.03
<b>2.4</b>	<b>Хуримтлагдсан ашиг (алдагдал)</b>	<b>(191,624,560,666.00)</b>	<b>(233,964,641,783.99)</b>
	<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>1,047,656,191,858.56</b>	<b>1,002,067,509,559.51</b>
	<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>4,233,699,819,673.31</b>	<b>4,019,857,991,892.04</b>

## 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	314,704,029,052.34	252,650,129,712.76
2	Борлуулалтын өртөг	(311,316,216,457.30)	(203,276,041,629.48)
3	<b>Нийт ашиг (алдагдал)</b>	<b>(3,387,812,595.04)</b>	<b>49,374,088,083.28</b>
5	Хүүгийн орлого	7,117,192,808.16	1,081,036,353.52
6	Бусад орлого	26,242,199,891.68	22,596,048,789.10
7	Ерөнхий ба удирдлагын зардал	(21,637,904,671.78)	(18,491,826,070.06)
8	Санхүүгийн зардал	(125,294,686.21)	(128,931,025.30)
9	Бусад зардал	(24,551,591,276.72)	(1,392,111,431.68)
10	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз )	(23,769,778,217.50)	(53,851,086,887.39)
11	<b>Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)</b>	<b>(33,337,363,557.33)</b>	<b>(812,782,188.53)</b>
12	Орлогын татварын зардал / (буцаалт)	(7,009,109,706.74)	(3,946,584,726.47)
13	<b>Татварын дараах ашиг (алдагдал)</b>	<b>(40,346,473,264.07)</b>	<b>(4,759,366,915.00)</b>
14	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(40,346,473,264.07)	(4,759,366,915.00)
15	Бусад дэлгэрэнгүй орлого	2,506,895,097.81	(3,248,601,181.06)
16	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	2,506,895,097.81	(3,248,601,181.06)
17	<b>Орлогын нийт дүн</b>	<b>(37,839,578,166.26)</b>	<b>(8,007,968,096.06)</b>
18	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		



## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Хувь нийлүүлсэн хөрөнгө	Дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>1,216,300,340,598.47</b>	<b>20,473,517,828.28</b>	<b>(151,278,088,401.93)</b>	<b>1,085,495,770,024.82</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	(1,000.00)	1,000.00	-
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,216,300,340,598.47</b>	<b>20,473,516,828.28</b>	<b>(151,278,087,401.93)</b>	<b>1,085,495,770,024.82</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	(40,346,473,264.07)	(40,346,473,264.07)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	2,506,895,097.81	-	2,506,895,097.81
<b>2020 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>1,216,300,340,598.47</b>	<b>22,980,411,926.09</b>	<b>(191,624,560,666.00)</b>	<b>1,047,656,191,858.56</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	-	-	(37,580,714,202.99)	(37,580,714,202.99)
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>1,216,300,340,598.47</b>	<b>22,980,411,926.09</b>	<b>(229,205,274,868.99)</b>	<b>1,010,075,477,655.57</b>
Тайлант үеийн цэвэр ашиг, алдагдал	-	-	(4,759,366,915.00)	(4,759,366,915.00)
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	-	(3,248,601,181.06)	-	(3,248,601,181.06)
<b>2021 оны 12-р сарын 31-ний өдрийн үлдэгдэл</b>	<b>1,216,300,340,598.47</b>	<b>19,731,810,745.03</b>	<b>(233,964,641,783.99)</b>	<b>1,002,067,509,559.51</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2020 оны 12-р сарын 31	2021 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
1.1	<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	470,365,781,844.41	179,454,192,573.41
1.1.1	Бараа Борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	133,434,766,732.89	109,449,024,218.10
1.1.2	Буцаан авсан албан татвар /Ханшийн хэрэгжсэн ашиг/	104,592,831.24	-
1.1.3	Татаас, санхүүжилтийн орлого /Зээл, мөнгөн хад-н цэвэр мөнгөн урсгал/	2,116,601,211.01	-
1.1.4	Бусад мөнгөн орлого /урьдчилж төлөгдсөн төлбөр/	334,709,821,069.27	70,005,168,355.31
1.2	<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	355,950,762,416.05	172,496,016,439.22
1.2.1	Ажиллагчдад төлсөн	9,031,492,396.42	6,118,532,716.12
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	1,263,535,378.07	907,423,048.38
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	68,293,813.00	31,320,276.88
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	304,669,425.45	312,937,705.60
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хэрэгсэл, сэлбэг хэрэгсэлд төлсөн	83,248,240.52	58,311,656.01
1.2.6	Хүүгийн төлбөрт төлсөн	174,119,598,175.62	160,988,406,438.76
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	723,575,259.21	60,358,237.53
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	229,102,284.79	166,199,280.38
1.2.9	Бусад мөнгөн зарлага	170,127,247,442.97	3,852,527,079.56
	<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>114,415,019,428.36</b>	<b>6,958,176,134.19</b>
<b>2</b>	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
2.1	<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	1,385,472,837.12	-
2.1.2	Хүлээн авсан хүүгийн орлого	1,385,472,837.12	-
2.2	<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	23,781,237,910.13	268,280,640.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	453,673,660.13	174,260,640.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	79,454,250.00	94,020,000.00
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	23,248,110,000.00	-
	<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(22,395,765,073.01)</b>	<b>(268,280,640.00)</b>
<b>3</b>	<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>		
3.1	<i>Мөнгөн орлогын дүн (+)</i>	90,905,700,000.00	162,182,688,371.24
3.1.2	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	90,905,700,000.00	162,182,688,371.24
3.2	<i>Мөнгөн зарлагын дүн (-)</i>	194,885,359,557.94	195,370,390,600.82
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн	194,725,072,209.50	194,770,573,163.04
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	25,815,183.65	-
3.2.3	Валютын ханшийн зөрүү	134,472,164.79	599,817,437.78
	<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>(103,979,659,557.94)</b>	<b>(33,187,702,229.58)</b>
<b>4</b>	<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>(11,960,405,202.59)</b>	<b>(26,497,806,735.39)</b>
<b>5</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>372,444,684,974.81</b>	<b>360,484,279,771.86</b>
<b>6</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>360,484,279,772.23</b>	<b>333,986,473,036.47</b>

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана гэж заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд банкны дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал, аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад удирдлагын тогтолцоог сайжруулах, хууль, дүрэм, журмын хэрэгжилтийг хангуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 02 дугаар сарын 10-наас 2022 оны 03 дугаар сарын 15-ны хооронд Грант Торнтон аудит ХХК-ийн аудитын багийн хянан удирдагч партнер Н.Эрдэнэцог, багийн ахлагч партнер Б.Дэлгэрмаа, багийн гишүүн менежер Л.Болорцэцэг, менежер С.Уянга нар тус тус хэрэгжүүлсэн.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайланг Үндэсний аудитын газарт 2022 оны 02 дугаар сарын 15-ны өдрийн 2/147 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Дотоод хяналт

Банкны удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзсэн.

Банк өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж, мөрдөөгүй байна.

Дотоод аудит, хяналтын алба нь 2021 онд 11 аудит гүйцэтгэх ажлын төлөвлөгөөний төслийг ТУЗ-д хүргүүлсэн боловч батлагдаагүй байна.

Аудитын эрсдэлийн хорооны даргын баталсан удирдамжийн дагуу 6 чиглэлд аудит хийж гүйцэтгэхдээ төлөвлөгөөт 4 аудит, төлөвлөгөөт бус 2 аудитыг хийсэн байна. Дотоод аудитаар өгөгдсөн нийт 60 зөвлөмжийн хэрэгжилт дараах байдалтай байна.

- Хэрэгжсэн 13 зөвлөмж 90 хувь -100 хувь
- Хэрэгжих шатанд 19 зөвлөмж 50 хувь - 89 хувь
- Хэрэгжилт хангалтгүй 4 зөвлөмж 10 хувь - 49 хувь
- Огт хэрэгжээгүй 9 зөвлөмж
- Хэрэгжилт үнэлэх хугацаа болоогүй 13 зөвлөмж байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Нэгтгэсэн санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ

илэрхийлснээр нэгтгэсэн санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн аудитын зорилго оршино.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн талаар холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалыг судлах аудитын горим хэрэгжүүлснээр Нягтлан бодох бүртгэлийн болон Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн Сангийн сайдын баталсан 2017 оны Аж ахуйн нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар 361 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтын дагуу нэгтгэсэн санхүүгийн тайлангаа бэлтгэж, толилуулсан гэж үзсэн.

Тус банк нь 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, Сангийн сайдын 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрийн 46-р тушаалаар батлагдсан Аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг хүлээн авах, хянах, нэгтгэл хийх, нэгтгэлийн мэдээллийг ашиглах журам-ын дагуу санхүүгийн тайлангаа улсын хэмжээнд нэгтгүүлэх үүднээс санхүүгийн тайлангийн и-баланс системд цахим хэлбэрээр хүргүүлдэг тусгай зорилго бүхий, үнэн зөв толилуулгын дагуу бэлтгэсэн, энэхүү тайланг ашиглах хэрэглэгчийн хувьд хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### **3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгөөр сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл Их гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийн 4,046,059.3 сая төгрөгөөс 0.5 хувиар буюу 20,230.3 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн тодруулга**

### **4.1 Байгууллагын үйл ажиллагаа**

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн зорилго нь Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, Монгол Улсын хөгжлийн тэргүүлэх болон стратегийн ач холбогдол бүхий салбарын үндэсний үйлдвэрлэл, экспортыг дэмжиж нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжилд хувь нэмэр оруулахад оршино.

Банкны дүрэмд тус байгууллагын үйл ажиллагааны чиглэлийг үндэсний эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах тэргүүлэх салбаруудад хэрэгжих төсөл, хөтөлбөрийг санхүүжүүлэх, импортыг орлох, экспортын орлогыг нэмэгдүүлэх үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх гэж тодорхойлжээ.

Банкны улсын бүртгэлийн гэрчилгээнд Хязгаарлагдмал Хариуцлагатай компани статустай бөгөөд 100.0 хувь төрийн (Сангийн яам) эзэмшилд байна.

### **4.2 Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй эрх зүйн орчин**

Монгол Улсын Засгийн газар 2010 оны 7 дугаар сарын 20-ны өдөр Монгол Улсын Хөгжлийн банкныг байгуулахаар шийдвэрлэж, Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын Хөгжлийн

банкны тухай хуулийг 2011 оны 02 дугаар сарын 10-ны өдөр баталж, 2011 оны 05 дугаар сарын 12-ны өдөр албан ёсоор байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд Засгийн газар нь төрийн өмчийн бүрэн бүтэн байдлыг Улсын Их Хурлын өмнө хариуцах бөгөөд энэ талаар дараах бүрэн эрхтэй: ... 5/ хуульд өөрөөр заагаагүй бол төрийн өмчит хуулийн этгээдийг байгуулах, өөрчлөх, татан буулгах тухай шийдвэр гаргах, түүний дүрмийг батлах;... гэсэн заалттай нийцэж байна.

Банкны удирдлага болон ТУЗ-ийн бүрэлдэхүүнийг Сангийн сайдын 2021 оны 06 дугаар сарын 18-ны өдрийн 97 дугаар тушаалаар томилсон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 6 дахь заалттай нийцэж байна.

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн цалин, урамшууллыг 61.1 сая төгрөгөөр тогтоосон нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 12 дахь заалт, Засгийн газрын 2016 оны 80 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд төрийн өмчийн төлөөллийг хэрэгжүүлэх журам-ын 3.7-д ...цалин хөлсний хэмжээг тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны хүрээ, санхүү, эдийн засгийн байдлыг харгалзан Хувьцаа эзэмшигчдийн хурал тогтооно. Цалин хөлсний хэмжээ нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлснээс ихгүй байна гэсэн заалттай нийцэж байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр-ийн 4.4.10-т Төрийн болон орон нутгийн өмчийн бүртгэл, ашиглалт, хамгаалалтыг сайжруулж, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн засаглалыг олон улсын жишигт нийцүүлэх, газрын хууль тогтоомжийг төрийн байгууламж нэгдмэл байх зарчим болон өмчийн эрх зүйд нийцүүлэн боловсронгуй болгоно гэж заасан байна.

Энэ хүрээнд Банкны засаглалыг сайжруулахаар ажилтнуудыг сургалтад хамруулах, төрийн байгууллагын нэгдмэл байх зарчмын дагуу Банкнаас бэлтгэдэг тайлан, мэдээг боловсронгуй болгох зэрэг арга хэмжээ авсан байна.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгосон 2 ажилтан, ажлаас чөлөөлөгдсөн 27 ажилтан нийт 29 ажилтны оронд 29 ажилтан авсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай тогтоолын 1.2. шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр цалингийн зардлыг хэмнэх; гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна

Тайлант хугацаанд Банкны санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол банкны Ерөнхийлөгчийн 2020.12.24-ний өдрийн А-470 дугаар тушаалаар Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам шинэчилсэн (Дагаж мөрдөх огноо: 2021-01-15) )
- Гүйцэтгэх захирлын 2021.12.07-ны өдрийн А-124 дүгээр тушаалаар Төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын журам
- Гүйцэтгэх захирлын 2021.12.28-ны өдрийн А-134 дүгээр тушаалаар Хөрөнгийн үнэлгээ тогтоох журам зэргийг баталсан.

### 4.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого

Монгол Улсын Хөгжлийн банк ХХК нь Монгол банкны нягтлан бодох бүртгэлийн багц материалд тулгуурлан дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтыг боловсруулж мөрдөх ёстой.

Тус банкны хэмжээнд Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн багц материал болон Гүйцэтгэх захирлын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн А-124 тушаалаар Төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын журам-ыг батлан, төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын үйл ажиллагаандаа хэрэгжүүлж байна. Журам батлагдахаас өмнө үйл ажиллагаандаа ашиглаж байсан 2018 онд ТУЗ-өөр батлагдсан Нягтлан бодох бүртгэлийн бодлого-ыг хүчингүй болгосон байна.

Банкны мөрдөж буй Төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын журам нь 10 зүйл, 6 хавсралттай бөгөөд нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналаас илүүтэйгээр төлбөр, тооцоо зохицуулдаг бол Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн багц материал нь Монгол Улсын банкны секторт тохиолддог нийтлэг ажил гүйлгээг хамруулдаг учраас Монгол Улсын Хөгжлийн банкны онцлог үйл ажиллагаа, тухайлбал СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-т хамаарах зээлийн үнэ цэнийн бууралт, өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн сан зэрэг тус банкинд тохиолдож буй онцлог бүртгэлийн асуудлуудыг бүхэлд нь хамарч зохицуулахгүй юм.

Иймд банкны дагаж мөрдөж буй Нягтлан бодох бүртгэл (НББ)-ийн бодлоготой холбоотой баталсан журам болон Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн багц материал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3-р зүйлийн 3.1.9-д заасан Нягтлан бодох бүртгэлийн бодлого гэсэн тодорхойлолтыг хангахгүй, 18-р зүйлийн 18.2-т заасан *Аж ахуйн нээж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана* гэсэн заалтад нийцэхгүй байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн үзүүлэлт

Банкны тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу бэлтгэгдсэн байна.

Банкны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаар нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 213,841.8 сая төгрөгөөр буурсан байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	360,484,279.8	333,986,473.0	(26,497,806.7)
Авлага	16,792,669.6	13,026,291.0	(3,766,378.6)
Богино хугацаат хөрөнгө оруулалт	1,173,519,909.5	486,284,614.9	(687,235,294.6)
Бараа материал	7,890.6	11,996.9	4,106.4
Урьдчилж төлсөн зардал/ тооцоо	8,604,300.7	1,757,989.4	(6,846,311.3)
Санхүүгийн түрээсийн авлага	85,259,492.9	74,062,793.0	(11,196,699.9)
Үндсэн хөрөнгө	26,354,730.4	25,005,852.9	(1,348,877.5)
Биет бус хөрөнгө	535,143.0	381,199.8	(153,943.2)
Урт хугацаат хөрөнгө оруулалт	2,326,097,484.7	2,833,602,666.7	507,505,182.0
Бусад эргэлтийн бус хөрөнгө	236,043,918.7	251,738,114.4	15,694,195.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>4,233,699,819.7</b>	<b>4,019,857,991.9</b>	<b>(213,841,827.8)</b>

Өглөг	36,884,922.8	18,252,876.9	(18,632,045.9)
Богино хугацаат өглөг	112,658,488.9	70,462,329.7	(42,196,159.3)
Урт хугацаат өглөг	3,036,500,216.1	2,929,075,275.8	(107,424,940.4)
Эзэмшигчдийн өмч	1,047,656,191.9	1,002,067,509.6	(45,588,682.3)
<b>Нийт эх үүсвэр</b>	<b>4,233,699,819.7</b>	<b>4,019,857,991.9</b>	<b>(213,841,827.8)</b>

Өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, санхүүгийн түрээсийн авлага, урт хугацаат хөрөнгө оруулалт, бусад эргэлтийн бус хөрөнгө өр төлбөрийн дансуудад дараах материаллаг өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

- Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 333,986.5 сая төгрөг болж 26.5 сая төгрөгөөр буурсан нь 3 хүртэлх сарын хугацаатай Монгол банкны үнэт цаасны хугацаа дуусч, хаагдсанаас шалтгаалсан байна.
- Авлага данс 3,766.4 сая төгрөгөөр буурсан нь охин компаниудыг татан буулгах шийдвэрийн дагуу дансны авлагыг 2,899.0 сая төгрөг, барилга байгууламжтай холбоотой нэмэгдсэн өртгийн албан татварын авлагыг 5,471.0 сая төгрөгөөр тус тус барагдуулснаар буурсан бол Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас авах зээлийн хүүгийн хөнгөлөлтийн авлага 4,603.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Урьдчилж төлсөн зардал данс 6,846.3 сая төгрөгөөр буурсан нь тайлант онд Монгол банкны бодлогын хүү буурсантай холбоотойгоор тооцооллын дагуу зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй олгосон зээлийн урьдчилгааг хаасан байна.
- Санхүүгийн түрээсийн авлага 11,196.7 сая төгрөгөөр буурсан нь Ди Би Эм лизинг ХХК-ийг татан буулгах шийдвэр гарсантай холбогдуулан нэмж санхүүгийн түрээс олгоогүй, зарим түрээсүүд бүрэн төлөгдсөнөөс шалтгаалсан байна.
- Үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгийн данс тайлант оны 1,503.0 сая төгрөгийн элэгдлийн зардлаар буурсан байна.
- Урт хугацаатай хөрөнгө оруулалт 507,505.2 сая төгрөгөөр өссөн нь 2021 оны 11 дүгээр сард Эрдэнэс таван толгой ХК-ийн 142,4000.0 сая төгрөгийн үнэт цаасанд хөрөнгө оруулж, 365,1000.0 сая төгрөгийн урт хугацаатай зээл олгосон нь нөлөөлсөн байна
- Бусад эргэлтийн бус хөрөнгө 15,694.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд хойшлогдсон татварын хөрөнгийн тооцооллоор 8,864.0 сая төгрөг, орон нутгийн ЗДТГ-тай Төрийн орон сууцны корпорац ХХК-ийн орон сууцны гэрээ байгуулж авлагаар бүртгэсэн хөрөнгө, Капитал банкны авлагаас барагдуулсан үл хөдлөх хөрөнгө нийт 71,872.4 сая төгрөгийн хөрөнгийг өмчлөх бусад үндсэн хөрөнгөөр бүртгэснээр тус тус нэмэгдсэн байна. Мөн Монголбанктай байгуулсан **своп** арилжааны хугацаа дууссантай холбоотойгоор санхүүгийн үүсмэл хэрэглүүр 65,042.2 сая төгрөгөөр буурсан байна.
- Дансны өглөг 18,632.0 сая төгрөгөөр буурсан нь охин компаниудыг татан буулгах шийдвэрийн дагуу дансны өглөгийг 20,293.0 сая төгрөгөөр, цалингийн өглөгийг 16.0 сая төгрөгөөр тус тус төлж барагдуулснаар хасагдаж, тайлант хугацааны татварын өглөг 1,676.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.
- Богино хугацаат өглөг данс 42,196.2 сая төгрөгөөр буурсан нь гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан хадгаламжийн үлдэгдэл 28,929.1 сая төгрөг, хүүгийн өглөг 1,032.1 сая төгрөг тус тус эргэн төлсөн нь нөлөөлсөн байна.
- Гадаадын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл болон банкнаас гаргасан өрийн бичиг, өмнө нь авсан эх үүсвэрүүдийн төлөлт хуваарийн дагуу төлөгдөж, Монгол банк болон дотоодын арилжааны банкуудад гаргасан өрийн бичгүүдийн хугацаа дуусч төлөгдсөнөөр урт хугацаат зээл 107,343.0 сая төгрөгөөр буурсан байна.
- Эздийн өмч 45,589.0 сая төгрөгөөр буурсан нь өрийн бичиг болон хувьцааны зах зээлийн үнэ цэнэ, Монголын Ипотекийн Корпорацийн хувьцааны үнэлгээ буурсантай

холбоотойгоор хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү 3,248,601.2 сая төгрөгөөр буурч тайлант хугацаанд 4,759.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласнаар хуримтлагдсан алдагдал 42,340.0 сая төгрөгөөр нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Тайлант хугацаанд төлөвлөгөөний дагуу шинэ зээлийн олголт хийгдээгүй бөгөөд охин компаниудыг татан буулгах шийдвэртэй холбоотойгоор борлуулалтын орлого, хүүгийн орлого нь өмнөх оны мөн үеийнхээс 6.0 хувиар буурсан байна.

- Тайлант хугацаанд гарсан нийт борлуулалтын өртөг буюу хүүгийн зардал өмнөх оны мөн үеийнхээс 47.0 хувиар буурсан байна. Энэ нь Зээлийн удирдлагын хорооны хурлын шийдвэрийн дагуу зээлийн эрсдэлийн сангийн тооцооллыг Төлөөлөн удирдах зөвлөлд танилцуулж, шийдвэрлүүлэхийг хүлээж байгаатай холбогдуулан тайлант хугацаанд эрсдэлийн сан нэмж байгуулаагүйтэй холбоотой байна.

Нийт борлуулалтын өртөг 203,276.0 сая төгрөгийг нэр төрлөөр нь задалбал:

- Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүгийн зардал 36,596.0 сая төгрөг
- Банк, санхүүгийн байгууллагаас байршуулсан хөрөнгийн хүүгийн зардал 1,055.0 сая төгрөг
- Өрийн бичгийн хүүгийн зардал 138,428.0 сая төгрөг
- Үнэ цэнийн бууралтын зардал 27,197.0 сая төгрөгөөр тайлагнасан байна.

Бусад орлогын хувьд нийт 22,596.0 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 41.0 хувиар буурсан бөгөөд энэ нь ковидын халдварт цар тахлын хязгаарлалтын улмаас охин компаниудын арилжааны банкуудад байршуулсан харилцахын хүүгийн орлого буурсантай холбоотой байна.

Мөн ерөнхий ба удирдлагын зардал 18,865.3 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 15.0 хувиар буурсан байна.

Санхүүгийн зардал болон бусад зардлын өмнөх оны мөн үеийнхээс 16.6 дахин буюу 23,156.0 сая төгрөгөөр буурсан нь авлагаар бүртгэгдсэн хөрөнгийг мөнгө түүнтэй адилтгах хөрөнгөд бүртгэж, уг хөрөнгийн эрсдэлийн сангийн зардал буурсан байна.

Гадаад валютын ханшийн зөрүүний гарз 53,478.0 сая төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеийнхээс 56.0 хувиар өссөн, үүсмэл санхүүгийн хэрэглүүрийн үнэлгээний тэгшитгэлийн гарзаас шалтгаалан байна.

Тайлант хугацаанд хойшлогдсон татварын хөрөнгийн тооцоололд үндэслэн 3,946.5 сая төгрөгийн орлогын албан татварын зардал бүртгэсэн байна.

Өрийн бичиг болон хувьцааны зах зээлийн үнэ цэнэ буурсантай холбоотойгоор үүссэн хөрөнгийн бодит үнэ цэнийн зөрүү 3,249.0 сая төгрөгийг Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүүгээр бүртгэж, тайлагнасан байна.

#### **4.5. Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл**

Тус банкны 2021 оны бизнес төлөвлөгөөг Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, банкны дүрмийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл баталдаг боловч нэгтгэсэн бизнес төлөвлөгөө баталдаггүй байна.

### **5. Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.



## 5.1 Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Монгол Улсын Хөгжлийн банк нь тайлант онд нийт 2,179.0 сая төгрөгийн 51 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод байршуулахаас 644.3 сая төгрөгийн Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон Бусад хэсгийн нийт 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.3-т тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, 6 дугаар зүйл 6.1-д Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөх.

## 5.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Банк нь 2017 оны 4 дүгээр сарын 01-нээс хойш нийт 2,159,584.6 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд эдгээрээс экспортыг дэмжсэн нийт 54 төсөл, хөтөлбөрийн зээлийн дүн нь нийт зээлийн багцын 58.4 хувийг эзэлж байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн шинэчилсэн хуулийн 8.2 Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна гэсэн заалтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хуулийн хэрэгжилтийг хангах, цаашид ЭКСИМ банкны чиг үүргийг хэрэгжүүлэн экспортыг дэмжсэн төсөл хөтөлбөрийг санхүүжүүлэх чиглэлээр бодлогын арга хэмжээг авч ажиллах албан шаардлага хүргүүлэх

2. Монгол Улсын Хөгжлийн банк нь тусдаа хуулиар зохицуулагддаг банкны статустай байгууллага боловч төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын нийтлэг дагаж мөрдөх шаардлагатай тогтоол, дүрэм, журмыг мөрдөхийг холбогдох төрийн байгууллагуудаас шаарддаг байна. Тухайлбал ТӨБЗГ-ийн 2021 оны 494 тоот албан бичгээр тус банкны ашиглаж байгаа 2 автомашиныг төрийн өөр байгууллагад балансаас балансад шилжүүлэхийг үүрэг болгосон нь Хөгжлийн банкны хараат бус байдалд нөлөөлөх, цаашид Хөгжлийн банкны хөрөнгийн удирдлага, төсөв санхүүгийн төлөвлөгөө, хүний нөөцийн өөрчлөлт зэрэг асуудлуудыг Хөгжлийн банк нь бие даан шийдвэрлэх эсвэл төрийн бусад байгууллагуудын адил тогтоол, шийдвэр, журмын хэрэгжилтийг дагаж мөрддөг байх эсэхийг нэг талд нь гаргаж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.

Шийдвэрлэсэн нь: Хөгжлийн банк нь Төрийн өмчит байгууллагын дагаж мөрдөх тогтоол, шийдвэр, журмыг мөрдөж ажиллах эсэхийг тодорхой болгохоор албан шаардлага хүргүүлэх

3. Нийт санхүүжүүлсэн зээлээс 56.0 хувь буюу 1,793,913.9 сая төгрөг нь чанаргүй зээлийн ангилалд орж, зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлд ороход: зээл олголтын шийдвэрийг хараат бусаар гаргах тогтолцоо бүрдээгүй, банкны зохистой засаглалын зарчим бүрэн хэрэгжээгүй, зээлийн шийдвэр гаргуулахдаа зээлийн судалгаа дүгнэлт хангалтгүй хийдэг, төслийн хэрэгжих боломж, ашигт ажиллагаа, эргэн төлөгдөх чадвар, зээлийн эрсдэлийг

нарийн тооцдоггүй, зээл олгосны дараах хяналтыг зохистой хийдэггүй, дотоодын зах зээлд (төгрөгөөр) орлого олдог зээлдэгчдэд валютаар зээл олгосноор валютын ханшийн дарамтад орох магадлал, эрсдэлийг харгалзаагүйгээр зээл олгосон, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн тогтворгүй байдалтай холбоотой бодлого журмын өөрчлөлт, хүний нөөцийн халаа сэлгээ, бодлогын залгамж чанар алдагдсан, Хөгжлийн банкны хуульд орсон өөрчлөлтийн улмаас ТУЗ-д хэт их эрх мэдэл олгосон, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхтэй холбоотой зарим нэг шийдвэр нь улс төрийн нөхцөл байдал, ковидын хүндрэл-ийн улмаас шалтгаалсан зээлийн эргэн төлөлтийн удаашрал чанаргүй зээл бий болоход ихээхэн нөлөөлсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Хөгжлийн банкны зээлийн шийдвэр гаргалтад хөндлөнгөөс нөлөөлөлгүй бие даан гаргадаг тогтолцоо засаглалын болон үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтуудыг бий болгох албан шаардлагыг Сангийн яаманд хүргүүлэх

*Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар*

Илрүүлэлт:

4. Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн багц материалд тулгуурлан дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтгүй байна. Тухайлбал:
  - Монгол Улсын Хөгжлийн банкны онцлог үйл ажиллагаа, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-т хамаарах бүртгэлийн бодлогыг тусгаагүй, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний А-470 дугаар тушаалаар баталсан Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам-д Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг СТОУС-ын дагуу тооцно гэж заасан боловч СТОУС-д энэ талаар тусгайлсан заалт байхгүй бөгөөд банканд энэ талаар зохицуулсан нарийвчилсан бодлого, журамгүй,
  - Өмнөх НББ-ийн бодлогыг хүчингүй болгож, 2021 онд батлагдсан Төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын журам нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагыг хангаагүй,
  - Монгол Улсын Хөгжлийн Банк нь бусад арилжааны банкнаас ялгарах онцлог бүхий ажил гүйлгээг бүртгэх бодлогыг нарийвчлан зааж өгөөгүй,
  - Стандартаар зохицуулаагүй эсвэл сонголт бүхий бүртгэлийн асуудлуудыг зохицуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүй,
  - Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг зохицуулсан нарийвчилсан журамгүй,
  - Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой аймаг, нийслэлд худалдсан хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг хэрхэн бүртгэх бодлого нь тодорхойгүй тул холбогдох гэрээний хүү, торгуулийн алданги зэрэг нь балансын гадуур бүртгэлтэй байна.

Өгсөн зөвлөмж:

Банк өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль, Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль, тогтоомжтой нийцээгүй байна.

## 6. Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайлангийн аудитыг төрийн аудитын байгуулагаас анх удаа хийж буй аудит бөгөөд аудитын тендер нь хугацаа алдаж зохион байгуулагдсанаас шалтгаалан завсар үеийн аудит хийгдээгүй болно.

Монгол Улсын Хөгжлийн банкны үйл ажиллагаа доголдож, хүндрэлд орсон асуудлуудын нэг хүчин зүйл бол төрийн аудитын байгууллагаас жил бүр санхүүгийн тайлангийн аудит хийгддэггүйтэй холбоотой байна. Хэрэв энэхүү аудит жил бүр хийгдэж явсан бол акт, албан шаардлага, зөвлөмжийг цаг тухайд нь өгч, хэрэгжилтийг нь тухай бүрд нь үнэлж, холбогдох албан тушаалтан, зээлдэгч нартай хариуцлага тооцож, хувьцаа эзэмшигчид, хууль тогтоогчдын анхааралд өртүүлж, цаг алдалгүй арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж, өнөөдрийн энэ хүндрэлтэй нөхцөлд хүрэхээргүй арга хэмжээ авах бололцоотой байхаар байна.

Аудитын явцад 2019 онд Үндэсний аудитын газраас хийгдсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн 6 зөвлөмжийн хэрэгжилтийг үнэлж үзэхэд 47.0 хувийн биелэлттэй байна.

Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 29-р зүйлийн 29.1-д заасны дагуу *Хөгжлийн банкны санхүүгийн тайланд төлөөлөн удирдах зөвлөлийн шийдвэрээр сонгосон олон улсын нэр хүнд бүхий аудитын байгууллагаар жил бүр аудит хийлгэж, дүгнэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн хамт төлөөлөн удирдах зөвлөлөөс Монголбанк, Засгийн газарт хүргүүлнэ* гэж заасны дагуу 2012, 2016-2017 онуудад Делойт Онч Аудит ХХК, 2013-2015 онуудад ПрайсвотерхаусКуперс аудит ХХК, 2018-2021 онуудад Кэй Пи Эм Жи аудит ХХК зэрэг олон улсын аудитын компаниуд тус тус аудит хийж, эдгээр компаниудад нийт 2,669.7 сая төгрөгийн аудитын төлбөрийг төлсөн байна.

Гэвч эдгээр аудитын компаниуд тус банкны санхүүгийн тайланд дүгнэлтээ илэрхийлэхдээ зээлийн чанар муудаж, эргэн төлөлт хүндэрч, чанаргүй зээлийн ангилалд орсоор байтал байгуулбал зохих эрсдэлийн санг журмын дагуу байгуулах талаар банкны тайланд залруулга, тохируулга хийгээгүй, жил жилийн санхүүгийн тайланд АОУС-д заасан өөрчлөлттэй санал дүгнэлтийг илэрхийлдэггүй, байнга зөрчилгүй санал дүгнэлт өгч байсныг анхаарч, цаашид олон улсын аудитыг үр дүнтэй байлгах, төрийн аудитын байгууллагаас хийдэг санхүүгийн аудитыг тогтмолжуулах шаардлага байгаа нь харагдаж байна.

## 7. Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар банкны санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн өмчлөх бусад үндсэн хөрөнгийн үнэлгээ, түүний эрсдэлийн сангийн хүлэн зөвшөөрөлтийн талаар нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.

Мөн доор дурдсан зээлийн төслүүд болон Хөгжлийн банкны охин компаниудын хувьд Үндэсний аудитын газраас гүйцэтгэлийн аудит хийх шаардлагатай гэж үзэж байна. Үүнд:

- Монгол Улсын Хөгжлийн банкнаас Тавантолгойн цахилгаан станцыг барих төслийн бэлтгэл ажлыг хангахад зориулан Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээг Эрчим хүчний яам, Эдийн засгийн Хөгжлийн яамтай байгуулан нийт 15.9 сая долларын зээлийг 2014 онд олгосон ба зээлийн хугацаа 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр дуусна. Зээлдэгч буюу Эрчим хүчний яам нь гэрээний 5.1.4 Төслийн нэгж нь зээлийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд хяналт тавих үүрэгтэй ба Эрчим хүчний яам гэрээгээр хүлээсэн үүргээ хэрэгжүүлсэн эсэх, 15.9 сая доллар буюу 45,641.2 сая төгрөгийн зээлийг төслийн зориулалтын дагуу, үр өгөөжтэй зарцуулсан эсэх
- Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-тай 2017 онд Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-г байгуулж 10.6 сая ам.долларын зээлийг олгосон ба зээлийн хугацаа 2021 оны

3 дугаар сарын 31-ний өдрөөр дууссан боловч зээлийн эргэн төлөлт хийгдээгүй нийт 15.0 сая ам.долларын 43,038.3 сая төгрөгийн зээлийн зөрчилтэй байна. Захиалагч буюу Эрчим хүчний яам нь гэрээний 10.1.1 Зээлийн хөрөнгийг үр дүнтэй зарцуулах, зээлдэгчийн үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж ажиллах үүрэгтэй ба Захиалагч гэрээний үүргээ хэрэгжүүлсэн эсэх, Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд олгосон 10.6 сая доллар зээлийн зарцуулалт болон төслийн хэрэгжилт,

- Хөгжлийн банкны охин компани болох Ди Би Эм ассет менежмент ҮЦК ХХК болон Ди Би Эм Лизинг ХХК-дын анх үүсгэн байгуулагдсан цагаас өнөөг хүртэл явуулсан санхүүгийн болон үйл ажиллагаа нь үр ашигтай бөгөөд анх байгуулсан зорилгоо хэрэгжүүлсэн эсэх.

## 8. Аудитын илрүүлэлт

Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 983,118.9 сая төгрөгийн 18 алдаа зөрчил илэрснээс 90.5 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 950,400.9 сая төгрөгийн 12 алдаа зөрчилд албан шаардлага хүргүүлж, 32,627.5 сая төгрөгийн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

Залруулагдаагүй 983,118.9 сая төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон 20,230.3 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс их тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

### 8.1 Төлбөрийн акт

1. Банк нь зочин төлөөлөгчийн зардалд 9.2 сая төгрөг, баяр ёслол арга хэмжээний зардалд 22.6 сая төгрөг, спорт арга хэмжээний зардалд 12.3 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46.4 сая төгрөг нийт 90.5 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байгаа нь МУЗГ-ын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоол болон ТӨБЗГ-ийн 2021 А-1/354 тоот Албан даалгавар хүргүүлэх тухай-д заасан сургалт, семинар, хурал зөвлөгөөн, хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж зардлыг хэмнэх болон баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын өдөр зэргийг зохион байгуулахгүй байх, байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоол, эрх бүхий дээд Төрийн байгууллагаас өгсөн албан даалгаврыг хэрэгжүүлээгүй тул төлбөрийн акт тогтоох.

### 8.2 Албан шаардлага

1. Ажлаас чөлөөлөгдсөн 14 хүнд 192.0 сая төгрөгийн тэтгэмж, ажилтнуудад 98.0 сая төгрөгийн эрүүл мэндийн халамж нийт 290.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал олгосон нь МУЗГ-ын 2021 оны Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоол болон ТӨБЗГ-ийн 2021 А-1/354 тоот Албан даалгавар хүргүүлэх тухай-д заасан сургалт, семинар, хурал зөвлөгөөн, хяналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж зардлыг хэмнэх болон баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын өдөр зэргийг зохион байгуулахгүй байх, байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Засгийн газрын тогтоол, эрх бүхий дээд Төрийн байгууллагаас өгсөн албан даалгаврыг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэх.

2. Банк нь 122 ажилтантай ба оффисын талбайн 1 ажилтанд ногдох хэмжээ 26.56 кв ба ихэнх талбай нь хурлын өрөөний зориулалтаар тодорхой ашиглалтгүй байна. Гэвч охин

компаниуд нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, тайлант онд нийт 209.0 сая төгрөгийг түрээсийн зардалд зарцуулж байна. Монгол улс хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, ажлын байрны орчинд мөрддөг MNS 5027:2001 стандартад заасанчлан 1 хүнд ногдох талбайн хэмжээ 6 мкв байдаг ба энэ хэмжээнээс хэтрүүлэн зардал гаргаж байгаа нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа Ди Би Эм Ассет менежмент ХХК болон Ди Би Эм Лизинг ХХК зэрэг охин компаниудын түрээсийн зардлыг хэмнэх, МУХБ-ны байрны сул зай талбайг ашиглах талаар албан шаардлага хүргүүлэх.

3. Монгол Улсын Хөгжлийн банкнаас ТОСК ТӨХК-д олгосон зээлийн хүрээнд Засгийн Газрын 2018 оны 81 дүгээр тогтоол, 2019 оны 233 дугаар тогтоол болон ТУЗ-ийн холбогдох тушаалд заасны дагуу Нийслэл, Хөвсгөл, Говь-Алтай, Орхон аймгуудын Засаг дарга нартай уг аймгуудад байршилтай, нийт 109,081.5 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгуудыг 5 жилийн хугацаанд, жилийн 6.0 хувийн хүүтэй нөхцөлөөр худалдан борлуулж, Хөгжлийн банканд эргүүлэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулсан байна. Тухайн аймаг, нийслэлийн ЗДТГ-ууд нь гэрээнд заасан хуваарийн дагуу зээлийг эргэн төлөх үүргээ биелүүлээгүйгээс нийт 21,461.7 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүү, алданги хуримтлагдсан байна.

**Шийдвэрлэсэн нь:** Төлөгдөөгүй хуримтлагдсан үндсэн төлбөр, хүү, алдангийг барагдуулах, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх

4. Банк нь тайлант хугацаанд өөрийн хөрөнгийн зохистой хэмжээ болон олон улсын үнэлгээ буурснаар бондоор босгосон гадаад эх үүсвэр эргэн татагдах, Монгол улсын зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлээс шалтгаалан зээлийн эрсдэлийн санг 792,679.8 сая төгрөгөөр төгрөгөөр дутуу байгуулсан байна. Энэ нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А-470 дугаар тушаалаар Монгол Улсын Хөгжлийн Банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам-ыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зээлийн эрсдэлийн санг журмын дагуу үнэн зөв бодитоор байгуулах албан шаардлага хүргүүлэх

5. Банкны цэвэршүүлээгүй авлагаас 12,740.2 сая төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй харилцагчтай байгуулсан гэрээ, түүнд тооцсон алданги, албан бичиг, Шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн бүртгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.6. эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Авлагыг тооцоо нийлж, актаар баталгаажуулах албан шаардлага хүргүүлэх

6. Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Дархан арьс ширний цогцолбор төслийн санхүүжилтэд шаардагдах зээлийн хүүгийн татаас хэлбэрээр нийт 15,000.0 сая төгрөг туссан бөгөөд бондын үндсэн төлбөрийн нөхцөл бүрдвэл уг хөрөнгөөр өрийн бичгийг хугацаанаас нь өмнө эргүүлэн төлөх нөхцөлтэй өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК болон Дархан арьс ширний цогцолбор ХХК хооронд 5 жилийн хугацаатай байгуулсан байна. Гэрээний дагуу төлөх нийт 6,488.4 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдөөгүй, зээлдэгчээр зээлийн гэрээний үүргийг биелүүлж ажиллаагүй байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21 дүгээр

зүйлийн 21.6.7 Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны өмнө хүлээсэн бусад этгээдийн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зээлийн гэрээний үүргийг биелүүлж ажиллах, зээлийн төлбөрийг барагдуулах албан шаардлага хүргүүлэх

7. Мавангүй ХХК-ийн 2,183.3 сая төгрөгийн зээлийн үүргийн гүйцэтгэлд банкны өмчлөлд 2019 онд шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгүүд нь борлогдоогүй бөгөөд тус банканд мэдэгдэлгүй хувь хүмүүстэй гэрээлж, банкны хөрөнгүүдийг борлуулсан нь шүүхээр нотлогдсон. Уг үл хөдлөх хөрөнгөд Монголбанкны Ерөнхийлөгчийн Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмын 2.3.4. Бусад санхүүгийн бус хөрөнгийг Хөгжлийн банкны эзэмшилд бүртгэснээс хойш 3 сарын хугацаанд багтаан ашиглах зориулалтыг тодорхойлж, Нягтлан бодох бүртгэлийн зааврын дагуу зохих дансанд шилжүүлэн бүртгэн холбогдох ангиллыг хийж, эрсдэлийн сан байгуулна гэсний дагуу эрсдэлийн сан байгуулаагүй байна. *(Мавангүй ХХК нь МУХБ-ны өмчлөлд шилжүүлсэн орон сууцнуудыг 2018, 2019 онуудад иргэдтэй орон сууц захиалгын гэрээ, хувь лизинг болон бартер хэлбэрээр худалдан борлуулсан, түрээслүүлснээ санаатай нуун дарагдуулсан, зохион байгуулалттай төлөвлөж үйлдсэн, бусдын эд хөрөнгө, түүнийг өмчлөх эрхийг хуурч мэхлэх, итгэл эвдэх аргаар олж авсны улмаас банканд их хэмжээний хохирол учруулсантай холбогдуулж шүүхийн ажиллагаа явагдаж байна)*

**Шийдвэрлэсэн нь:** Өмчлөх бусад хөрөнгөд эрсдэлийн сан байгуулах албан шаардлага хүргүүлэх

8. ТУЗ-ын 2013 оны 12 дугаар тогтоолоор баталсан Ажилтнуудад зээл олгох журам-ын дагуу орон сууцны хөнгөлөлттэй зээл олгосон 3 ажилтныг 2020 онд ажлаас чөлөөлсөн ба тайлант хугацааны эцэст нийт 195.1 сая төгрөгийг орон сууцны зээлийн гэрээний 13.6-д заасны дагуу арилжааны банкны энгийн харилцагчийн ижил төрлийн зээл рүү шилжүүлээгүй санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгөд бүртгэж байгаа нь эрх ба үүрэг, үнэн, зөв зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ын баталсан “Ажилтнуудад зээл олгох журам”-ыг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

9. ТУЗ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол, Гүйцэтгэх захирлын Б-97 тушаалын дагуу Хөрөнгө оруулалтын газрын Бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн захирал С.Ган-Эрдэнэтэй Гадаадад мэргэжил дээшлүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ-г байгуулан Люксембургийн их сургуульд суралцах сургалтын төлбөр болон амьжиргааны зардалд зориулан 55.0 сая төгрөг санхүүгийн дэмжлэг олгосон байна. Сургалтын дэмжлэгийн 32.9 сая төгрөгийн үлдэгдэл урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй хэвээр байна. Энэ нь Гадаадад мэргэжил дээшлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ-ний 3.2.1; 3.2.3 заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн нь:** Гэрээний үүргийг биелүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх

10. Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор зээлийг Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлд Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор-ын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-аар дамжуулан 7,055,255 ам.долларын зээлийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр олгосон. Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор уг тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж олгосон нийт 25,649.9 сая төгрөгийг, үүнээс зээл, зээлийн хүү нийт 10.4 сая ам.доллар буюу 153.1 сая төгрөгийг улсын төсөвт тусгах, Батлан хамгаалах яамны балансад шилжүүлэхээр заасан боловч уг тогтоолыг хэрэгжүүлээгүй

байна. Зээлийн эргэн төлөлт хийгдээгүй тул 2019 оны 12 дугаар 25-нд шүүхэд нэхэмжлэл гаргаж, 3 шатны шүүхийн процессоор хянан хэлэлцүүлж, дахин анхан шатны шүүхэд шилжсэн ба 2021 оны 05 дугаар 25-ны өдөр хариуцагчийн зөвшөөрлийг баталсан шүүгчийн захирамж гарч, шүүхийн маргааныг шийдвэрлүүлсэн боловч шүүхийн тогтоолыг хэрэгжүүлээгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зээл, зээлийн хүүгийн төлбөр болон холбогдох бусад зардлыг барагдуулах албан шаардлага хүргүүлэх

11. Монгол Улсын Хөгжлийн банк нь 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-тай ТС-ЭГ-ЗҮ 2017/131 дугаартай Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-г байгуулж, гэрээний дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-д 10.6 сая ам.долларын зээлийг хэсэгчлэн олгосон ба зээлийн хугацаа 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж зээл, зээлийн хүү, торгуулийн төлбөр нийт 15.0 сая ам.доллар буюу 43,038.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна. Монгол Улсын Хөгжлийн банк нь Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-ний 10.1.4-т заасны дагуу зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж зээл, зээлийн хүүгийн төлбөрийг Улсын төсөвт тусгуулан төлүүлэх шаардлагыг Эрчим хүчний яаманд удаа дараа хүргүүлсэн боловч зээлийн зөрчлийг арилгаагүй нь гэрээний үүргийн биелэлтийг хангуулж ажиллаагүй байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.6.7 Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны өмнө хүлээсэн бусад этгээдийн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулж, зээл, зээлийн хүүг төлүүлэх албан шаардлага хүргүүлэх

12. Засгийн газрын 2013 оны 80 тогтоолыг үндэслэн Эрчим хүчний яам, Эдийн засгийн Хөгжлийн яам болон Монгол Улсын Хөгжлийн банкны хооронд Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээг 2013 онд байгуулж, Тавантолгойн цахилгаан станцыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулан эхний ээлжинд 1.9 сая ам.долларын зээл олгосон байна. Улмаар Засгийн газрын 2014 оны 261 дүгээр тогтоолын дагуу төслийн бэлтгэл ажилд шаардлагатай санхүүжилт болон Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай З-ДЦ-Б 2014-09 дугаартай гэрээг дахин шинэчилж нийт 15.9 сая долларын зээл олгосон байна. Зээлийн хугацаа гэрээний дагуу 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр дуусах бөгөөд тайлант хугацааны эцэст 1.2 сая доллар буюу 45,641.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн зөрчилтэй байна. Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 21.6.7-д Гүйцэтгэх удирдлага нь Хөгжлийн банкны өмнө хүлээсэн бусад этгээдийн үүргийг хангуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ гэсэнтэй нийцэхгүй байна.

**Шийдвэрлэсэн нь:** Монгол Улсын Хөгжлийн банкнаас Тавантолгойн цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулан олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулж, “Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ”-ний дагуу үүргээ хэрэгжүүлж, зээлийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх.

### 8.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

#### 1. Үл хөдлөх хөрөнгийн үнэ цэнийн бууралтын талаар

##### Илрүүлэлт:

Монгол Улсын Хөгжлийн Банк нь 2016 онд Худалдаа хөгжлийн банкны Сүхбаатар дүүргийн 1 хороонд байрлах оффисын барилгын 11 болон 12 давхрын 3,240.36 мкв талбай болон 163.1 мкв 10 авто зогсоолыг зах зээлийн үнээс 3,000.0 - 4,000.0 сая төгрөгөөр өндөр үнээр буюу 27,731.0 сая төгрөгөөр худалдан авсан байна. Банк нь эдгээр үл хөдлөх хөрөнгийг өртгөөр нь бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан ба анх худалдан авснаас хойш НББОУС-36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт-н 9-д Аж ахуйн нэгж нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ заалтыг хэрэгжүүлээгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

НББОУС 36-ийн заасны дагуу хөрөнгийн үнэ цэнийн бууралтын шинжилгээ, судалгааг гүйцэтгэж байх зөвлөмж өгөх.

#### 2. Авлага дансны бүртгэлийн талаар

##### Илрүүлэлт:

Нийслэл, Хөвсгөл, Говь-Алтай, Орхон аймгуудын ЗДТГ-ууд Хөгжлийн банктай нийт 109,081.5 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгуудыг 5 жилийн хугацаанд, жилийн 6 хувийн хүүтэй нөхцөлөөр худалдан борлуулж, эргүүлэн төлөх гэрээг байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс хуримтлагдсан 4,494.6 сая төгрөгийн зээлийн хүү, алдангийг Хөгжлийн банк нь санхүүгийн тайланд авлагаар хүлээн зөвшөөрөөгүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6.1-д Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтөлнө гэсэн заалт, үнэн, зөв байх, батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

##### Өгсөн зөвлөмж:

Худалдан борлуулах гэрээнд заасан хуваарийн дагуу алданги торгуулийг төлүүлэх, Балансын гадуур бүртгэлтэй авлагыг данс бүртгэлд бүртгэж нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөн санхүүгийн тайланг үнэн зөв бодитой илэрхийлэх нь зүйтэй.

#### 3. Эх үүсвэрийн ашиглалтын талаар

##### Илрүүлэлт:

МУХБ-ны 2013 оны ТУЗ-ын 12 дугаар тогтоолоор Ажилтнуудад зээл олгох журам-ыг баталж, 1,000.0 сая төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банканд тэг хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай байршуулан, арилжааны банк нь ажилтнуудад 6 хувийн хүүтэйгээр ипотекийн зээлийг олгодог байна. 2022 оны 02 сарын 14-ний өдрийн байдлаар Төрийн банк болон Голомт банкнаас олгосон зээлийн үлдэгдэл 626.5 сая төгрөг байсан ба 373.5 сая төгрөгийг үр ашиггүй байршуулсан нь банкны хүүгийн орлогыг бүрдүүлэх боломжийг алдаж байна. Ашиглагдаагүй хадгаламжийн үлдэгдлийн алдагдсан боломжийн хэмжээг мөнгөн дүнгээр тооцвол жилийн 26.0 сая төгрөг ба зээлийн хугацаа 10 жил гэж үзвэл нийт 260.0 сая төгрөгийн орлого олох боломжийг алдахаар байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1.төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах; заалтыг зөрчсөн байна. МУХБ-ны тухай хуулийн 5 дугаар зүйл ..... энэ хуулийн 8.1-д заасан үйл ажиллагааг эрхлэх чиг үүрэг бүхий ашгийн төлөө хуулийн этгээд байна гэсэн заалттай нийцэхгүй байна.



**Өгсөн зөвлөмж:**

Арилжааны банкуудад байршуулсан ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэлд хүү тооцуулах, эсвэл гэрээнд өөрчлөлт оруулах замаар 0 хувьтай эх үүсвэрийг буцаан татаж, банкны үйл ажиллагаанд ашиглах.

**4. Дахин ангиллын бүртгэлийн талаар**

**Илрүүлэлт:**

Хэвлэл мэдээллийн зардлын 2023 онд хамаарах 28.4 сая төгрөгийн зардлыг тайлант хугацааны зардлаар тайлагнаж, үр дүнг буруу илэрхийлсэн байна.

**Өгсөн зөвлөмж:**

Зардлыг санхүүгийн тайлангийн тасалбар болголт, нотлох баримтад үндэслэн аккрузл сууриар бүртгэж, тайлант жилийн үр дүнг үнэн зөв бодитой илэрхийлэх.

**5. Хууль, журам, тогтоол шийдвэрийн зөрчлийн талаар**

**Илрүүлэлт:**

Хөгжлийн банкны олгосон нийт зээлийн 30 хувь буюу 961,750.3 сая төгрөг нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй ба зээлдэгчийн ирээдүйд олох орлого болон ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалсан байна. Ирээдүйд бий болох хөрөнгийг нэмж барьцаалах, барьцаа хөрөнгөөр баталгаажсан боловч чанаргүй ангилалд орсон зээлдэгчдийн зээлийн барьцаа хөрөнгийг хамгаалж, даатгалд хамруулахыг зээлдэгчдээс шаарддаггүй нь барьцаа хөрөнгийн чанар байдал муудах, аливаа эрсдэлд ороход банк хохирохоор байгаа нь Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийн 10.1.6-д “энэ хуулийн 8.1.7-д зааснаас бусад санхүүжилт нь Засгийн газрын өрийн баталгаа, барьцаа, баталгаа зэрэг үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэрэгслээр хангагдсан байх” заалттай нийцэхгүй байна.

**Өгсөн зөвлөмж:**

Зээлийг ирээдүйд бий болсон хөрөнгүүдээр нэмж барьцааны гэрээ байгуулж, баталгаажуулах, барьцаа хөрөнгөөр баталгаажсан боловч чанаргүй ангилалд орсон хөрөнгүүдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалд хамруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

9. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс							
					Тоо	Дүн	Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж	
							Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<b>Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн асуудлаар</b>														
1	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Банк нь зочин төлөөлөгчийн зардалд 9.2 сая төгрөг, баяр ёслол арга хэмжээний зардалд 22.6 сая төгрөг, спорт арга хэмжээний зардалд 12.3 сая төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46.4 сая төгрөг нийт 90.5 сая төгрөгийн үргүй зардал гаргасан байгаа байна. .	Тайлант оны үйл ажиллагааны бус тэвчиж болохуйц зарцуулалтыг Үндэсний аудитын газрын Төрийн сан банк дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоох	1	90,480.0			1	90,480.0				
2	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Ажлаас чөлөөлөгдсөн 14 хүнд 192 сая төгрөгийн тэтгэмж, ажилтнуудад 98 сая төгрөгийн эрүүл мэндийн халамж нийт 290.1 сая төгрөгийн тэтгэмжийн зардал олгосон байна.	Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/354 дугаар тушаалаар хүргүүлсэн албан даалгаврыг хэрэгжүүлээгүй зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэх.	1	290,072.0					1	290,072.0		
3	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Банк нь 122 ажилтантай ба оффисын талбайн 1 ажилтанд ногдох хэмжээ 26.56 кв ба ихэнх талбай нь хурлын өрөөний зориулалтаар тодорхой ашиглалтгүй байна. Гэвч охин компаниуд нь түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, тайлант онд нийт 209.0 сая төгрөгийг түрээсийн зардалд зарцуулж байна.	Түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа Ди Би Эм Ассет менежмент ХХК болон Ди Би Эм Лизинг ХХК зэрэг охин компаниудын түрээсийн зардлыг хэмнэж, Монгол Улсын Хөгжлийн банкны оффисын талбайн сул зай талбайг эдийн засгийн үр өгөөжтэй байдлаар ашиглах, албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-		

4	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Монгол Улсын Хөгжлийн банкнаас ТОСК ТӨХК-д олгосон зээлийн хүрээнд Засгийн Газрын 2018 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн 81 дүгээр тогтоол, 2019 оны 6 дугаар сарын 5-ны 233 дугаар тогтоол болон ТУЗ-ийн холбогдох тушаалд заасны дагуу Нийслэл, Хөвсгөл, Говь-Алтай, Орхон, Дундговь аймгуудын Засаг дарга нартай уг аймгуудад байршилтай, нийт 109,081.5 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгуудыг 5 жилийн хугацаанд, жилийн 6 хувийн хүүтэй нөхцөлөөр худалдан борлуулж, Хөгжлийн банканд эргүүлэн төлөх нөхцөлтэй гэрээ байгуулсан байна. Тухайн аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газрууд нь гэрээнд заасан хуваарийн дагуу зээлийг эргэн төлөх үүргээ биелүүлээгүйгээс нийт 21,461.7 сая төгрөгийн үндсэн төлбөр, хүү, алданги хуримтлагдсан байна.	Үл хөдлөх хөрөнгө зээлээр худалдах, худалдан авах гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлж ажиллах албан шаардлагыг Нийслэл, Аймгуудын засаг дарга нарт хүргүүлэх	1	21,461,659.6					1	21,461,659.6		
5	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Банк нь тайлант хугацаанд өөрийн хөрөнгийн зохистой хэмжээ болон олон улсын үнэлгээ буурснаар бондоор босгосон гадаад эх үүсвэр эргэн татагдах, Монгол улсын зээлжих зэрэглэлд сөргөөр нөлөөлөх эрсдэлээс шалтгаалан зээлийн эрсдэлийн санг 792,679.8 сая төгрөгөөр төгрөгөөр дутуу байгуулсан байна.	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны А-470 дугаар тушаалаар баталсан МУХБ-ны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг бүрэн хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	792,679,823.7					1	792,679,823.7		
6	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Банкны цэвэршүүлээгүй авлагаас 12,740.2 сая төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй харилцагчтай байгуулсан гэрээ, түүнд тооцсон алданги, албан бичиг, Шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн бүртгэсэн байна.	Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	12,740,260.4					1	12,740,260.4		

7	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Монгол Улсын 2020 оны төсвийн тухай хуульд Дархан арьс ширний цогцолбор төслийн санхүүжилтэд шаардагдах зээлийн хүүгийн татаас хэлбэрээр нийт 15,000.0 сая төгрөг туссан бөгөөд бондын үндсэн төлбөрийн нөхцөл бүрдвэл уг хөрөнгөөр өрийн бичгийг хугацаанаас нь өмнө эргүүлэн төлөх нөхцөлтэй өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээг Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК болон Дархан арьс ширний цогцолбор ХХК хооронд 5 жилийн хугацаатай байгуулсан байна. Гэрээний дагуу төлөх нийт 6,488.4 сая төгрөгийн зээлийн төлбөр төлөгдөөгүй, зээлдэгчээр зээлийн гэрээний үүргийг биелүүлж ажиллаагүй байна.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль болон Өрийн бичиг худалдах, худалдан авах гэрээний үүргийг зохих ёсоор биелүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	6,488,393.4					1	6,488,393.4		
8	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Мавангүй ХХК-ийн 2,183.3 сая төгрөгийн зээлийн үүргийн гүйцэтгэлд банкны өмчлөлд 2019 онд шилжүүлэн авсан үл хөдлөх хөрөнгүүд нь борлогдоогүй бөгөөд тус компани нь банканд мэдэгдэлгүй хувь хүмүүстэй гэрээлж банкны хөрөнгүүдийг борлуулсан нь шүүхээр нотлогдсон. Уг үл хөдлөх хөрөнгөд эрсдэлийн сан байгуулаагүй байна.	Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан Активыг ангилах, эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журмыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	2,183,280.0					1	2,183,280.0		
9	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	ТУЗ-ын 2013 оны 12 дугаар тогтоолоор баталсан Ажилтнуудад зээл олгох журам-ын дагуу орон сууцны хөнгөлөлттэй зээл олгосон 3 ажилтныг 2020 онд ажлаас чөлөөлсөн ба тайлант хугацааны эцэст нийт 195.1 сая төгрөгийг арилжааны банкны энгийн харилцагчийн ижил төрлийн зээл рүү шилжүүлээгүй санхүүгийн тайланд мөнгөн хөрөнгөд бүртгэсэн байна.	Монгол Улсын Хөгжлийн банкны ТУЗ-ын баталсан Ажилтнуудад зээл олгох журам-ыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	195,128.6					1	195,128.6		

10	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	ТУЗ-ын 2015 оны 41 дүгээр тогтоол, Гүйцэтгэх захирлын Б-97 тушаалын дагуу Хөрөнгө оруулалтын газрын Бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн захиралтай Гадаадад мэргэжил дээшлүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ-г байгуулан Люксембургийн их сургуульд суралцах сургалтын төлбөр болон амьжиргааны зардалд зориулан 55.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Гэрээнд заасан үүргийн дагуу ажилтан нь 2018 оноос МУХБ-ны охин компани болох Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК-д ажиллаж байтал МУ-ын Засгийн газрын 2020 оны 155 дугаар тогтоолын дагуу Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаж ажлаас нь чөлөөлсөн байна. Ажилтны сургалтад зориулан олгосон санхүүгийн дэмжлэг 32.9 сая төгрөгийн үлдэгдэл Урьдчилж төлсөн тооцоо дансанд бүртгэлтэй хэвээр байна.	Гадаадад мэргэжил дээшлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний холбогдох үүргийг зохих ёсоор биелүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	32,940.2					1	32,940.2		
11	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор зээлийг Засгийн газрын 2016 оны 60 дугаар тогтоолоор Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэлд Барилгын хийц үйлдвэрлэх хөдөлгөөнт цогцолбор-ын тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж Төрийн орон сууцны корпораци ТӨҮГ-аар дамжуулан 7,055,255 ам.долларын зээлийг 2016 оны 02 дугаар сарын 05-ны өдөр олгосон. Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолоор уг тоног төхөөрөмжийг худалдан авахад зориулж олгосон нийт 25,649.9 сая төгрөгийг, үүнээс зээл, зээлийн хүү нийт 10.4 сая ам.доллар буюу 153.1 сая төгрөгийг улсын төсөвт тусгах, Батлан хамгаалах яамны балансад шилжүүлэхээр заасан боловч хэрэгжүүлээгүй,	Засгийн газрын 2017 оны 48 дугаар тогтоолыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	25,649,932.4					1	25,649,932.4		

12	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Монгол Улсын Хөгжлийн банк нь 2017 оны 09 дүгээр сарын 06-ны өдөр Эрчим хүчний яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-тай ТС-ЭГ-ЗҮ 2017/131 дугаартай Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-г байгуулж, гэрээний дагуу Эгийн голын усан цахилгаан станц ТӨХК-д 10.6 сая ам.долларын зээлийг хэсэгчлэн олгосон ба зээлийн хугацаа 2021 оны 3 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болж зээл, зээлийн хүү, торгуулийн төлбөр нийт 15.0 сая ам.доллар буюу 43,038.3 сая төгрөгийн зээлийн эргэн төлөлт хийгдээгүй байна.	Монгол Улсын Хөгжлийн банкнаас Эгийн голын усан цахилгаан станцын төсөлд зориулж авсан зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулж, Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-ний дагуу үүргээ хэрэгжүүлж, зээлийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	43,038,292.3					1	43,038,292.3		
13	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Засгийн газрын 2013 оны 80 тогтоолыг үндэслэн Эрчим хүчний яам, Эдийн засгийн Хөгжлийн яам болон Монгол Улсын Хөгжлийн банкны хооронд Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээг 2013 онд байгуулж, Тавантолгойн цахилгаан станцыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулан эхний ээлжинд 1.9 сая ам.долларын зээл олгосон байна. Улмаар Засгийн газрын 2014 оны 261 дүгээр тогтоолын дагуу төслийн бэлтгэл ажилд шаардлагатай санхүүжилт болон Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай З-ДЦ-Б 2014-09 дугаартай гэрээг дахин шинэчилж нийт 15.9 сая долларын зээл олгосон байна. Зээлийн хугацаа гэрээний дагуу 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдөр дуусах бөгөөд тайлант хугацааны эцэст 1.2 сая доллар буюу 45,641.2 сая төгрөгийн зээлийн хүүгийн зөрчилтэй байна.	Монгол Улсын Хөгжлийн банкнаас Тавантолгойн цахилгаан станцын төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангахад зориулан олгосон зээлийг зориулалтын дагуу зарцуулсан эсэхийг баталгаажуулж, Төсөл санхүүжүүлэх, эргэн төлөлтийг зохицуулах тухай гэрээ-ний дагуу үүргээ хэрэгжүүлж, зээлийн зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэх	1	45,641,203.6					1	45,641,203.6		

14	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Монгол Улсын Хөгжлийн Банк нь 2016 онд Худалдаа хөгжлийн банкны Сүхбаатар дүүргийн 1 хороонд байрлах оффисын барилгын 11 болон 12 давхрын 3,240.36 кв талбай болон 163.1 кв 10 авто зогсоолыг зах зээлийн үнээс 3,000.0-4,000.0 сая төгрөгөөр өндөр үнээр буюу 27,731.0 сая төгрөгөөр худалдан авсан үл хөдлөх хөрөнгийг өртгөөр нь бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан байна.	Банк нь эдгээр үл хөдлөх хөрөнгийг өртгөөр нь бүртгэж, санхүүгийн тайланд тусгасан ба анх худалдан авснаас хойш НББОУС-36 Хөрөнгийн үнэ цэнийн бууралт-н 9-д Аж ахуйн нэгж нь хөрөнгийн үнэ цэнэ буурсан байж болох ямар нэг шинж тэмдэг байгаа эсэхийг тайлант үе бүрийн эцэст үнэлнэ заалтыг хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх.	1	27,731,006.4							1	27,731,006.4
15	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Нийслэл, Хөвсгөл, Говь-Алтай, Орхон, Дундговь аймгуудын ЗДТГ-ууд Хөгжлийн банктай нийт 109,081.5 сая төгрөгийн өртөг бүхий орон сууцны барилгуудыг 5 жилийн хугацаанд, жилийн 6 хувийн хүүтэй нөхцөлөөр худалдан борлуулж, эргүүлэн төлөх гэрээг байгуулсан боловч гэрээний үүргээ биелүүлээгүйгээс хуримтлагдсан 4,494.6 сая төгрөгийн зээлийн хүү, алдангийг Хөгжлийн банк нь санхүүгийн тайланд авлагаар хүлээн зөвшөөрөөгүй байна.	Худалдан борлуулах гэрээнд заасан хуваарийн дагуу алданги торгуулийг төлүүлэх, Балансын гадуур бүртгэлтэй авлагыг данс бүртгэлд бүртгэж нягтлан бодох бүртгэлээ аккрузл сууриар хөтлөн санхүүгийн тайланг үнэн зөв бодитой илэрхийлэх зөвлөмж өгөх.	1	4,494,589.1							1	4,494,589.1
16	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	МУХБ-ны 2013 оны ТУЗ-ын 12 дугаар тогтоолоор Ажилтнуудад зээл олгох журам-ыг баталж, 1,000.0 сая төгрөгийн эх үүсвэрийг арилжааны банканд тэг хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай байршуулан, арилжааны банк нь ажилтнуудад 6 хувийн хүүтэйгээр ипотекийн зээлийг олгодог байна. 2022 оны 02 сарын 14-ний өдрийн байдлаар Төрийн банк болон Голомт банкнаас олгосон зээлийн үлдэгдэл 626.5 сая төгрөг байсан ба 373.5 сая төгрөгийг үр ашиггүй байршуулж, МУХБ олж болох хүүгийн орлогыг алдаж, ашиглагдаагүй хадгаламжийн үлдэгдлийн алдагдсан боломжийн хэмжээг мөнгөн дүнгээр тооцвол жилийн 26.0 сая төгрөг ба зээлийн хугацаа 10 жил гэж үзвэл нийт	Арилжааны банкуудад байршуулсан ашиглаагүй эх үүсвэрийн үлдэгдэлд хүү тооцуулах, эсвэл гэрээнд өөрчлөлт оруулах замаар 0 хувьтай эх үүсвэрийг буцаан татаж, банкны үйл ажиллагаанд ашиглах зөвлөмж өгөх	1	373,460.5							1	373,460.5

			260.0 сая төгрөгийн орлого олох боломжийг алдахаар байна											
17	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Хэвлэл мэдээллийн зардлаас дараа онд хамаарах 28.4 сая төгрөгийг тайлант хугацааны зардлаар бүртгэн үр дүнг буруу илэрхийлсэн байна.	Зардлыг санхүүгийн тайлангийн тасалбар болголт, нотлох баримтад үндэслэн аккруэл сууриар бүртгэж, тайлант жилийн үр дүнг үнэн зөв бодитой илэрхийлэх зөвлөмж өгөх	1	28,440.0						1	28,440.0	
18	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/НА-СТА-ТӨА	Хөгжлийн банкны олгосон нийт зээлийн 30 хувь буюу 961,750.3 сая төгрөг нь барьцаа хөрөнгөөр баталгаажуулаагүй ба зээлдэгчийн ирээдүйд олох орлого болон ирээдүйд бий болох хөрөнгийг барьцаалсан байна. Барьцаа хөрөнгөөр баталгаажсан чанаргүй ангилалд орсон зээлдэгчдийн зээлийн барьцаа хөрөнгийг хамгаалж, сан даатгалд хамруулахыг шаарддаггүй нь барьцаа хөрөнгийн чанар байдал муудах, аливаа эрсдэлд ороход банк хохирохоор байна.	Зээлийг ирээдүйд бий болсон хөрөнгүүдээр нэмж барьцааны гэрээ байгуулж, баталгаажуулах, барьцаа хөрөнгөөр баталгаажсан боловч чанаргүй ангилалд орсон хөрөнгүүдийг эрсдэлээс хамгаалах зорилгоор даатгалд хамруулах зөвлөмж өгөх	1	-						1	-	
<b>ДҮН</b>					<b>18</b>	<b>983,118,962.2</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>1</b>	<b>90,480.0</b>	<b>12</b>	<b>950,400,986.2</b>	<b>5</b>	<b>32,627,496.0</b>



д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа зөрчлийн утга	Тогтоосон акт, албан шаардлага өгсөн зөвлөмжийн утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс									
							Залруулга		Акт		Албан шаардлага		Зөвлөмж			
					Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн		
<b>Нэгтгэсэн санхүүгийн тайлангийн асуудлаар шалгасан нийцлийн асуудал</b>																
1	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/Н А-СТА-ТӨА	Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн багц материалд тулгуурлан дотооддоо СТОУС болон Монгол улсад мөрдөгдөж буй хууль, дүрэм, журамд бүрэн нийцсэн, нягтлан бодох бүртгэлийн бодлого, журам, дансны дэлгэрэнгүй жагсаалтгүй байна. Тухайлбал: - Монгол Улсын Хөгжлийн банкны онцлог үйл ажиллагаа, СТОУС 9 Санхүүгийн хэрэглүүр-т хамаарах бүртгэлийн бодлогыг тусгаагүй, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2020 оны 12 дугаар сарын 24-ний А-470 дугаар тушаалаар баталсан Хөгжлийн банкны активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулах, зарцуулах журам-д Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг СТОУС-ын дагуу тооцно гэж заасан боловч СТОУС-д энэ талаар тусгайлсан заалт байхгүй бөгөөд банканд энэ талаар зохицуулсан нарийвчилсан бодлого, журамгүй, - Өмнөх НББ-ийн бодлогыг хүчингүй болгож, 2021 онд батлагдсан Төлбөр тооцоо, бүртгэл, санхүүгийн тайлагналын журам нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын шаардлагыг хангахгүй, - Монгол Улсын Хөгжлийн Банк нь бусад арилжааны банкнаас ялгарах онцлог бүхий ажил гүйлгээг бүртгэх бодлогыг нарийвчлан зааж өгөөгүй, - Стандартаар зохицуулаагүй эсвэл сонголт бүхий бүртгэлийн асуудлуудыг зохицуулсан нягтлан бодох бүртгэлийн бодлого байхгүй, - Өмчлөх бусад хөрөнгийн эрсдэлийн санг зохицуулсан нарийвчилсан журамгүй, - Өмчлөх бусад хөрөнгөтэй холбоотой аймаг, нийслэлд худалдсан хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг хэрхэн бүртгэх бодлого нь тодорхойгүй тул холбогдох гэрээний	Банк өөрийн үйл ажиллагааны онцлогт нийцсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулан мөрдөж ажиллах Зөвлөмж өгөх	1	-									1	-

			хүү, торгуулийн алданги зэрэг нь балансын гадуур бүртгэлтэй байна.											
2	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/Н А-СТА-ТӨА	Банк нь 2017 оны 4 дүгээр сарын 01-нээс хойш нийт 2,159,584.6 сая төгрөгийн зээл олгосон бөгөөд эдгээрээс экспортыг дэмжсэн нийт 54 төсөл, хөтөлбөрийн зээлийн дүн нь нийт зээлийн багцын 58.4 хувийг эзэлж байна.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-		
3	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/Н А-СТА-ТӨА	Монгол Улсын Хөгжлийн банк нь тусдаа хуулиар зохицуулагддаг банкны статустай байгууллага боловч төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагуудын нийтлэг дагаж мөрдөх шаардлагатай тогтоол, дүрэм, журмыг мөрдөхийг холбогдох төрийн байгууллагуудаас шаарддаг байна. Тухайлбал ТӨБЗГ-ийн 2021 оны 494 тоот албан бичгээр тус банкны ашиглаж байгаа 2 автомашиныг төрийн өөр байгууллагад балансаас балансад шилжүүлэхийг үүрэг болгосон нь Хөгжлийн банкны хараат бус байдалд нөлөөлөх, цаашид Хөгжлийн банкны хөрөнгийн удирдлага, төсөв санхүүгийн төлөвлөгөө, хүний нөөцийн өөрчлөлт зэрэг асуудлуудыг Хөгжлийн банк нь бие даан шийдвэрлэх эсвэл төрийн бусад байгууллагуудын адил тогтоол, шийдвэр, журмын хэрэгжилтийг дагаж мөрддөг байх эсэхийг нэг талд нь гаргаж шийдвэрлэх зайлшгүй шаардлагатай байна.	Хөгжлийн банк нь Төрийн өмчит байгууллагын дагаж мөрдөх тогтоол, шийдвэр, журмыг мөрдөж ажиллах эсэхийг тодорхой болгохоор албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-		

4	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/Н А-СТА-ТӨА	Нийт санхүүжүүлсэн зээлээс 56.0 хувь буюу 1,793,913.9 сая төгрөг нь чанаргүй зээлийн ангилалд орж, зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэлд ороход: зээл олголтын шийдвэрийг хараат бусаар гаргах тогтолцоо бүрдээгүй, банкны зохистой засаглалын зарчим бүрэн хэрэгжээгүй, зээлийн шийдвэр гаргуулахдаа зээлийн судалгаа дүгнэлт хангалтгүй хийдэг, төслийн хэрэгжих боломж, ашигт ажиллагаа, эргэн төлөгдөх чадвар, зээлийн эрсдэлийг нарийн тооцдоггүй, зээл олгосны дараах хяналтыг зохистой хийдэггүй, дотоодын зах зээлд (төгрөгөөр) орлого олдог зээлдэгчдэд валютаар зээл олгосноор валютын ханшийн дарамтад орох магадлал, эрсдэлийг харгалзаагүйгээр зээл олгосон, ТУЗ болон гүйцэтгэх удирдлага, тэдгээрийн тогтворгүй байдалтай холбоотой бодлого журмын өөрчлөлт, хүний нөөцийн халаа сэлгээ, бодлогын залгамж чанар алдагдсан, Хөгжлийн банкны хуульд орсон өөрчлөлтийн улмаас ТУЗ-д хэт их эрх мэдэл олгосон, Засгийн газрын мөрийн хөтөлбөрөө хэрэгжүүлэхтэй холбоотой зарим нэг шийдвэр нь улс төрийн нөхцөл байдал, ковидын хүндрэл-ийн улмаас шалтгаалсан зээлийн эргэн төлөлтийн удаашрал чанаргүй зээл бий болоход ихээхэн нөлөөлсөн байна.	Монгол Улсын Хөгжлийн банкны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах, албан шаардлага хүргүүлэх	1	-					1	-		
5	Монгол Улсын Хөгжлийн банк ХХК	АХГ-2022/47/Н А-СТА-ТӨА	МУХБ нь тайлант онд нийт 2,178.8 сая төгрөгийн 51 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 644.3 сая төгрөгийн Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт болон Бусад хэсгийн нийт 5 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.	Энэ нь шилэн дансны тухай хуулийн хэрэгжүүлж ажиллах зөвлөмж өгөх	1	644,323.0						1	644,323.0	
<b>ДҮН</b>					<b>5</b>	<b>644,323.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>3</b>	<b>0.0</b>	<b>2</b>	<b>644,323.0</b>
<b>НИЙТ ДҮН</b>					<b>23</b>	<b>983,763,285.2</b>	<b>0</b>	<b>0.0</b>	<b>1</b>	<b>90,480.0</b>	<b>15</b>	<b>950,400,986.2</b>	<b>7</b>	<b>33,271,819.0</b>



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2022 оны 03 дугаар сарын 15

№ 137/А0150053

Улаанбаатар хот

АХГ-8022/50/НА - СТАБ-ТОА

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Хөгжлийн банк нь тайлант онд зочин төлөөлөгчийн зардалд 9,170,306.50 төгрөг, баяр ёслол, арга хэмжээний зардалд 22,584,300.00 төгрөг, спорт арга хэмжээний зардалд 12,325,070.00 төгрөг, хэвлэл мэдээллийн зардалд 46,400,000.00 төгрөг нийт 90,479,676.50 төгрөгийн үргүй зардал гаргасан байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 2021 оны 43 дугаар тогтоол болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Албан даалгавар хүргүүлэх тухай" А-1/354 дугаар тушаалд заасан сургалт, семинар, хурал зөвлөгөөн болон газар дээрх яналт шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж зардлыг хэмнэх болон баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын тэмцээн, салбарын өдөр зэргийг зохион байгуулахгүй байх, байгууллага, хамт олныг сурталчлах, салбарын болон байгууллагын үйл ажиллагаатай холбоотой нэвтрүүлэг, контент, баримтат болон цуврал кино зэргийг санхүүжүүлэхгүй байх" заалтуудыг хэрэгжүүлээгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 "Шалгаагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хэбсгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.-д заасныг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. Тайлант оны үйл ажиллагааны бус тэвчиж болохуйц зарцуулалт 90,479,676.50 төгрөг (ерэн сая дөрвөн зуун далан есөн мянга зургаан зуун далан зургаан төгрөг тавин мөнгө) төгрөгийг Үндэсний аудитын газрын Төрийн сан банкна дахь Аудитын шалгалтын орлогын 100900000601 тоот дансанд төвлөрүүлэх.
2. Актын биелэлтийг 2022 оны 9 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, Санхүүгийн газрын захирал Т.Баасанжав нарт хариуцуулав.

АКТ ТОГТООСОН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

*(Handwritten signatures)*


Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:  
ГРАНТ ТОНТОН АУДИТ ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
АУДИТОР

*(Handwritten signature)*

Б.ОСОРГАРАВ  
Б.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 11-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-261230



\\10.10.20\Bichig\_Kherig\Akt\2022\0315 Auditin 2 Газар-77.Docx

0001090347



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 625/А.0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/50/НА-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажлаас чөлөөлөгдсөн 14 ажилтанд 192,022,031.66 төгрөгийн тэтгэмж, ажилтнуудад 98,049,500.00 төгрөгийн эрүүл мэндийн халамж, нийт 290,071,531.66 төгрөгийн тэтгэмжийн зардал олгосон байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн 43 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Албан даалгавар хүргүүлэх тухай" А-1/354 дугаар тушаалд заасан шинээр ажлын чиг үүрэг, албан тушаал бий болгохгүй, орон тоог нэмэгдүүлэхгүй байх, өндөр насны тэтгэвэр тогтоолгож чөлөөлөгдсөн ажилтан, албан тушаалтны орон тоог царцааж, нөхөн томилгоо хийхгүйгээр, цалингийн зардлыг хэмнэх, зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгах, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх гэсэн албан даалгаврыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын А-1/354 дугаар тушаалаар хүргүүлсэн албан даалгаврыг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, Санхүүгийн газрын захирал Т.Баасанжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮИЦЭТГЭСЭН:  
ГРАНТ ТОНТОН АУДИТ ХХК-ЫН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
АУДИТОР

*(Handwritten signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Б.ОСОРГАРАВ  
Б.ДЭЛГЭРМАА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

9019120596

110-10-10-2010chug\_Mereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-369.Docx

0001021873



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 626/А0150053  
АХГ-2022/50/НА-СТА-ТӨА

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Монгол Улсын Хөгжлийн банкны цэвэршүүлээгүй авлагын нийт 16,576,843,976.29 төгрөгийн үлдэгдэлтэй байгаагаас 3,836,583,619.96 төгрөгийн авлагыг харилцагчтай тооцоо нийлж баталгаажуулсан ба үлдэх 12,740,260,356.33 төгрөгийн авлагад тооцоо нийлж баталгаажуулаагүй харилцагчтай байгуулсан гэрээ, түүнд тооцсон алданги, шүүхийн шийдвэр зэргийг үндэслэн бүртгэсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 зүйлийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

- Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
- Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, Санхүүгийн газрын захирал Т.Баасанжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН:  
ГРАНТ ТОРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
АУДИТОР

Б.ОСОРГАРАВ  
Б.ДЭЛГЭРМАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-264230

\\0.10.10.20\Bichig\_Kherig\Alban\_Shaardlaga\2022\0315\_Auditin\_2\_Gazar-358.Docx

0001021779



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 627/А0150053

Улаанбаатар хот

АХГ-2022/50/НА-СТА-ТӨА  
Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2015 оны 41 дүгээр тогтоол, Гүйцэтгэх захирлын Б-97 тушаалын дагуу Хөрөнгө оруулалтын газрын Бодлого, төлөвлөлт, судалгааны хэлтсийн захиралтай "Гадаадад мэргэжил дээшлүүлэх, санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ"-г байгуулан Люксембургийн их сургуульд суралцах сургалтын төлбөр болон амьжиргааны зардалд зориулан 55,000,000.00 төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна. Гэрээнд заасан үүргийн дагуу тус ажилтан нь 2018 оноос МУХБ-ны охин компани болох Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК-д ажиллаж байтал МУ-ын Засгийн газрын 2020 оны 155 дугаар тогтоолын дагуу Ди Би Эм Ассет менежмент ҮЦК ХХК-ийг татан буулгаж ажлаас нь чөлөөлсөн байна. Ажилтны сургалтад зориулан олгосон санхүүгийн дэмжлэг 32,940,217.40 төгрөгийн үлдэгдэл УТТ дансанд бүртгэлтэй хэвээр байна.

Энэ нь "Гадаадад мэргэжил дээшлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээ"-ний 3.2.3 "Ажил олгогчийн санаачилгаар ажилтны хөдөлмөрийн гэрээг цуцалсан нөхцөлд ажилтны хүлээх үүргийг хугацаанаас нь өмнө чөлөөлөх", 3.2.1 "Ажилтанд олгосон чөлөөний хугацаанд ажилтны одоогийн ажлын байрыг хадгалах, чөлөөний хугацаа дуусахад ажлын байраар хангах" гэсэн гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11. "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Гадаадад мэргэжил дээшлүүлэх санхүүгийн дэмжлэг үзүүлэх гэрээний холбогдох үүргийг зохих ёсоор биелүүлээгүй зөрчлийг арилгаж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх.
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мандуул, Санхүүгийн газрын захирал Т.Баасанжав нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ГЭРЭЭГЭЭР ГҮЙЦЭТГЭСЭН  
ГРАНТ ТӨРНТОН АУДИТ ХХК-ИЙН  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
АУДИТОР

*(Handwritten signature)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Д.ЭНХДАЛАЙ

Б.ОСОРГАРАВ  
Б.ДЭЛГЭРМАА

Монгол Улс Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,  
Утас 51-204230

9019120396

W:\10-10-20\Bichu\Khereg\Alban Shaardlaga\2022\0315 Auditin 2 Gazar-366.Docx

0001081795



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 03 дугаар сарын 15 № 628/АХГ-2022

Улаанбаатар хот

АХГ-2022/50/НБ-СТА-ТӨА

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8.9.8-д заасны дагуу Монгол Улсын Хөгжлийн банкны 2021 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Банк нь 2017 оны 4 дүгээр сарын 01-нээс хойш нийт 2,159,584,622,917.32 төгрөгийн зээл олгосон бөгөөд эдгээрээс экспортыг дэмжсэн нийт 54 төсөл, хөтөлбөрийн зээлийн дүн нь нийт зээлийн багцын 58.4 хувийг эзэлж байна.

Энэ нь Монгол Улсын Хөгжлийн банкны 2017 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн шинэчилсэн хуулийн 8.2 "Хөгжлийн банкнаас санхүүжүүлэх, баталгаа, батлан даалт гаргах нийт санхүүжилтийн дүнгийн 60-аас доошгүй хувийг экспортыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зарцуулна" гэсэн заалтыг зөрчсөн байна.

